



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№78 /522/

2023.05.16

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГАЛААХЫН САЙД ТУСГАЙ САЛБАРУУДАД АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Өмнөговь аймагт ажиллаж байна. Өнөөдөр Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын сайдын зөвлөх дэслэгч генерал Ц.Дашзэвэг, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, тус аймгийн Засаг даргын орлогч Н.Энхбат, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат нарын албаныхан Зэвсэгт хүчний АЦК-ын харьяа 065 дугаар ангийн тусгай салбаруудад ажиллалаа.

Батлан хамгаалахын сайдыг хүрэлцэн ирэхэд бие бүрэлдэхүүн жагсаж, ёслол төгөлдөр угтлаа. Салбаруудын захирагч хошууч Б.Улсбаяр, А.Сүрэнхүү нар тус тусын салбарын түүх, үйл ажиллагаа, дэвшүүлсэн зорилго зорилт, тулгамдсан асуудлуудаа танилцууллаа.

Үндсэн үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ офицер, ахлагч нарын ажиллаж, амьдрах

орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан албан тушаалын орон сууцны барилга, салбарын байрлал дахь объектуудын засвар, тохижилт болон туслах аж ахуйг хөгжүүлж байгаагаа уламжилсан.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр салбаруудын бие бүрэлдэхүүнтэй уулзаж, Засгийн газрын үйл ажиллагаа, Батлан хамгаалах бодлого, зорилтын талаар танилцуулав. Тэрбээр “Алсын хараа 2050” болон “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалах Зэвсэгт хүчний үүрэг оролцоо өндөр байгааг онцоллоо. Түүнчлэн Батлан хамгаалахын эрхзүйн шинэчлэл, Зэвсэгт хүчний ирэх зууны өнгө төрх сайд, удирдлагуудаас гадна Зэвсэгт хүчинд алба хааж байгаа хүн нэг бүрээс хамааралтай гэдгийг онцлоод цаашид эрхэлсэн ажилдаа эзэн болж, хандлагаа өөрчилж, хариуцлагаа

нэмэгдүүлэхийг уриалсан юм. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин нь сүүлийн жилүүдэд хөнгөн хуягт техникүүдийг өөрсдөө үйлдвэрлэж, зэвсэглэлд туршсаны зэрэгцээ бага бууны сумны үйлдвэр байгуулах болсноор цаашид бүтээн байгуулагч салбар болох үндэс суурь нь тавигдсаныг салбарын сайд хэллээ.

Мөн цаашид Зэвсэгт хүчин болон Агаарын цэргийн зэвсэглэл техникийг шинэчлэх, хөгжүүлэхэд тал бүрээр дэмжихээ илэрхийлж, бие бүрэлдэхүүнд ажлын өндөр амжилт, гэр бүлд нь аз жаргал эрүүл энхийг хүссэн юм.

Төгсгөлд нь Батлан хамгаалахын сайд салбаруудад тулгамдсан зарим асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэхийг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгож, олон үйлдэлт ухаалаг дэлгэц болон портер машины түлхүүрийг гардуулан өгөв.

Ахлах дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 10	☁️ -3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40	☁️ 29

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,458	3,464
EUR 🇪🇺	3,775	3,793
CNY 🇨🇳	499	500.50
RUB 🇷🇺	43.10	43.80
JPY 🇯🇵	25.80	26
KRW 🇰🇷	2.60	2.62

ЗУРХАЙ

2023.05.16 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 27

ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал: ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 05.13-20.24 Барилдлага: Үхэх ШҮТЭН БАРИЛДЛАГА: Хүрэлцэхүй

ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ БАГ АЖИЛЛАЖ БАЙНА



БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойш НҮБ-ын мандатад заагдсан үүргийн дагуу цэргийн багийн хариуцлагын бүсэд цагийн байдлыг тогтворжуулах, иргэдэд туслах, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйл хэрэгт бодит хувь нэмэр оруулаар байна.

Үүний нэг тод илрэл нь эзэн орны иргэдтэй хүнлэг энэрэнгүй харьцах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, НҮБ, Монгол Улсын Зэвсэгт хүчний үйл ажиллагааг орон нутагт сурталчлах зорилготойгоор “Харилцан ажиллагааны баг”-ийг томилгоожуулан тосгон, суурингуудад багагүй ажлыг хийж гүйцэтгээд байгаа юм. Тодруулбал, энэхүү харилцан ажиллагааны багийн бүрэлдэхүүн цэргийн багийн хариуцлагын бүс Бентью суурин дахь охидын сургууль болон Париян суурин дахь дунд сургуулийн сурагчдад туслах аяныг уг өрнүүлээд байна.

Тэд Бентью суурин дахь охидын сургуулийн сурагчдын танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс улс төрийн болон газар зүйн зурагт самбарыг танхимуудад байршуулан, гадаад орнуудын мэдээлэл, физик газар зүйн онцлогийн талаар ярилцаж, нэг өдрийг өнгөрүүлсэн бол Париян суурингийн сурагчидтай шатар, гар бөмбөг, гагнуур, авто засварын сургалтыг явуулж, одоогийн байдлаар 14 хүүхдийг хамруулаад

байна. Энэ үеэр Бентью суурингийн охидын сургуульд явагдсан ажил нь сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төдний ирээдүйд итгэх итгэл, урам зоригийг нэмэгдүүлэх, идэвхжүүлэх зорилготой явагдсан бол Париян сууринд явагдаж буй ажил нь орон нутгийн иргэдэд мэргэжил, боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, ажлын дадлага эзэмшүүлэх, цэргийн багийн үйл ажиллагааг сурталчилж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилготой явагдсан.

Дээрх ажилд цэргийн багийн эмэгтэй цэргийн алба хаагчид идэвхтэй оролцож байгаа нь онцлог юм.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР



БНФУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН АТТАШЕ ХУРАНДАА ЭЛПИДИО ТОМАС ФАКТОРЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ Бүгд Найрамдах

Филиппин Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин сайдын яамны Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе хурандаа Элпидио Томас Факторыг Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаатай холбогдуулан хүлээн авч уулзлаа. Уулзалтаар хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО



Батлан хамгаалах яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ Бүгд Найрамдах Польш Улсаас

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Элчин сайдын яамны Монгол Улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе бригадын генерал Станислав Кажинки-г Монгол Улсад ажлын айлчлал хийж байгаатай холбогдуулан хүлээн авч уулзлаа. Уулзалтаар хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

БХЯ-ГХАГ

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 688,379,964

Эдгэрсэн

Нийт: 660,813,344

Нас барсан

Нийт: 6,874,902

Цахим шууданд

БХЯ, ЗХЖШ-ЫН УДИРДЛАГА, БИЕ БҮРЭЛДЭХҮҮН "ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ДЭМЖИЖ ...



цогцолбор төв"-ийн ажилтнуудын хамтаар Зэвсэгт хүчний Мод үржүүлгийн төвд 100 гацуур, 8000 хайлаас, 1000 бургас модыг тарих ажлыг зохион байгуулав.

Уг ажилд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр, БХЯ-ны БХЗГ-ын дарга бригадын генерал М.Мөнхбаяр нарын хүндэт зочид оролцож, хамтдаа мод тарьсан бөгөөд Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаатай танилцаж, үүрэг, чиглэл өгч, дэмжиж ажиллахаа илэрхийлсэн юм.

Мод тарих ажлын эхэнд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Экологийн албаны дарга ахлах дэслэгч Ц.Болдсайхан бие бүрэлдэхүүнд мод тарих үеийн заавар, зөвлөмжийг өгч, биечлэн хяналт тавьсан нь үр дүнтэй болов.

Мөн энэ үеэр Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Мод үржүүлгийн төвийн дарга дэслэгч П.Лхамсүрэн, агрономич, ахлах сургагч дэслэгч Ө.Пүрэвдорж нартай уулзахад "Өнгөрсөн жил Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний энэ талбайд тарьсан бүхий л модыг сайтар усалж, арчилсны үр дүнд тун сайн ургаж байгаа. Бидний ажлын нэг онцлог нь мөчрийн үржүүлгийг маш олноор хийж, мандлын цэцэг тарьж байгаад чиглэгддэг" хэмээн онцолсон юм.

Уг мод үржүүлгийн төвд 10000 гаруй навчит болон шилмүүст модыг ургуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар бургасны харандаагаар 40000, улиасны харандаагаар 30000 гаруй мөчрийн үржүүлгийг хийсний зэрэгцээ үрээр тарьсан 30000 гаруй нэг настай гүйлсний суулгацыг бойжуулах талбайд шилжүүлэн суулгаж, арчилгаа, тордолтыг нь хийж байгаа ажээ.

**Хурандаа
Б.ОТГОНБАЯР**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, тэдгээрийн харьяа нэгтгэл, анги, байгууллагуудын нийт бие бүрэлдэхүүн манлайлан оролцож байна.

Тодруулбал, өнгөрсөн жилээс эхлэн Зэвсэгт хүчний хот, хөдөөгийн хэд хэдэн ангид Мод үржүүлгийн болон Мод үржүүлэг, сургалтын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулсны зэрэгцээ Зэвсэгт хүчний нэгтгэл, анги бүрийг эко-ногоон хотхон болгох ажлыг эрчимжүүлж байна.

Түүнчлэн гэр хороололд буюу хашаандаа амьдарч буй алба хаагчид, ахмад дайчдын дунд мод, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо тарьж ургуулах аяныг өрнүүлэн, зарим дэмжлэгийг үзүүлж буй нь зохих үр дүнд хүрч байна.

Харин энэ өдөр буюу 5 дугаар сарын 16-ны өдөр Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлага, бие бүрэлдэхүүн "Багабаян-Энхийн төлөө

ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД БҮТЭЭЛЧ АЖИЛ ӨРНҮҮЛЭВ



ойг тэмдэглэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабаас олон ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байгаагийн нэг нь энэ сарын 12-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан бүтээлч ажил юм.

Тодруулбал, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх "Монгол цэрэг-Энхийн төлөө" цогцолбор ашиглалтад ороод багагүй хугацаа өнгөрөөд байна. БХЯ, ЗХЖШ-аас "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд уг цогцолборын эргэн тойронд ногоон төгөл бий болгох зорилгыг дэвшүүлсэн бөгөөд энэ удаа уг цогцолборын орчин тойронд их цэвэрлэгээ хийж, мод тарих бэлтгэл ажлыг хангав.

Энэхүү бүтээлч ажилд ЗХЖШ, төрлийн цэргийн командлалын харьяа нэгтгэл, ангиуд, зарим төрийн цэргийн байгууллагын 200 гаруй алба хаагч нийгмийн хариуцлагын хүрээнд хамрагдсан юм.

**Дэд хурандаа
Т.МӨНГӨНШАТАР**

Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг оролцуулсаны 20 жилийн ой энэ онд тохиож байна. Энэхүү

АХЛАГЧИЙН АЛБЫГ СУРТАЛЧИЛЛАА



Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн "Ахлагчийн зөвлөл"-өөс "Ахлагчийг хөгжүүлэх хөтөлбөр-2024" баримт бичгийн хэрэгжилтийг хангах, ахлагчийн бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадамжийг дээшлүүлэх хүрээнд алба, салбараа сурталчлах аяныг 5 дугаар сарын 1-ний өдрөөс 12-ны өдрүүдэд зохион байгуулж явууллаа.

Энэхүү аянаар сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудаас гадна гар нийлэмжтэй ажиллагааг бэхжүүлсэн спорт өдөрлөгийг зохиосон юм. Тухайлбал, "Баримт бичгийн стандарт", "Тасгийн захирагчийн үүрэг" сэдвээр дэд ахлагч Б.Отгонлхагва, ахлах ахлагч Х.Түмэндэлгэр, "Мөрийтэй тоглоом, цахим орчинд үйлдэгдэж байгаа залилангийн гэмт хэрэг" сэдвээр ахмад Б.Оргил нар сургалт явуулж, мэдлэг мэдээлэл олгов. Мөн ахлагчийн албанд шинээр томилогдсон бүрэлдэхүүнд сурган

дадлагажуулах сургалтуудыг үе шаттайгаар явуулж, "Мөрдөстэй бүхний хичээллэж, гүйцэтгэж чаддаг байх спорт бол цэрэгжлийн спорт" сэдвээр яриа таниулга хийлээ.

Төгсгөлд нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд явагдаж байгаа ёс зүй, бие бялдрын үзлэгтэй уялдуулан ангийн офицер, ахлагч нарын дунд "Буухиа тэмцээн"-ийг явуулав. Алба хаагчид гар дээр суниалт, автоматын хагас задаргаа, угсаргаа, хими хамгаалах хэрэгсэл, суга савлуурт суниах, гэдэсний таталт гэсэн 6 цэгт ур чадвар, тэсвэр хатуужлаа сорин өрсөлдсөн юм.

Ахлагчийн албыг сурталчилснаар бүрэлдэхүүний хамтын ажиллагаа өргөжиж, сахилга хариуцлагаа дээшлүүлж, ажил, арга хэмжээнд ахлагчийн оролцоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн үр өгөөжтэй аян болж чадсан юм.

Ахлах дэслэгч Б.БЭРХБААТАР



ҮЗҮҮЛГИЙН ХЭСГИЙН "ХОЁР ДАХЬ АМЬДРАЛ" ЦОГЦЛОВ



2023 оны 5 дугаар сарын 16-ны өдөр "Зэвсэгт хүчний Соёл хүмүүжлийн ажилтны өдөр" тохионо. Энэхүү тэмдэглэлт өдрийн "битүүн"-д Монгол цэргийн музейн Төрөл мэргэжлийн цэргийн түүхийн танхимд "Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн байгууллагын түүхэн замнал" үзүүлгийн хэсгийн нээлт боллоо.

Энэ үзүүлэгийн хэсгийг дэглэх ажил 2017 оноос эхэлсэн бөгөөд анхны танхим мөн ондоо үүдээ нээснээс хойш Цэргийн Улс төрийн байгууллагын 100 жилийн ойг угтаж орчин үеийн загвар, өнгө төрх оруулан эд өлгийн зүйлсээр арвижсаар ийнхүү өдгөө анхны үзэгчдээ хүлээн авч байгаа ажээ.

"Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл" ТББ-ын тэргүүн, бэлтгэл хурандаа Б.Жуваа нээж хэлсэн үгэндээ "Түүхийн танхим цэргийн улс төрийн ажилтан бидний хамтын бүтээл юм. Музейн захирлаар ажиллаж байсан 1983 оны төгсөгч хурандаа З.Баярмагнай үзүүлэгийн хэсгийн танхимыг гаргаж өгч 1977 оны төгсөгч Ч.Цэен-Ойдов, Д.Батсүх нар "Цайз" захаас мод авчирч харуулдаг эхэлснээр ажил эхэлж байсан. 1983 оны төгсөгчид нийт ажлын 70 хувийг хариуцан гүйцэтгэж, 1981 оны төгсөгч Д.Баярсайхан, Д.Жамбалдорж нар 2 сая төгрөг, 1988 оны төгсөгч Ш.Элбэгдорж, 1993 оны төгсөгч Ш.Батбилэг нар тус бүр 1 сая төгрөг, 1990 оны төгсөгч хурандаа Б.Отгонбаяр, 1994 оны төгсөгч Энхтүвшин, Ардын багш Г.Мягмаржав нар тус бүр 500 мянга, Гавьяат багш А.Гэлэгжамц 300 мянган төгрөг хандивлаж, бэлтгэл дэд хурандаа Я.Одсүрэн эзэмшиж байсан хөгжмийн зэмсгүүдээ, ахмад ажилтан Ё.Саяням магнитофон, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, бэлтгэл хурандаа П.Наваансүрэн, бэлтгэл дэд хурандаа Ш.Нанзад нарын хүмүүс Цэргийн улс төрийн байгууллагын түүхэнд холбогдох баримт бичиг, гэрэл зургууд хандивласнаар үзүүлгийн хэсэг бүрдсэн. Цаашид үзмэрийг

улам баяжуулах, хээрийн ухуулгын цэгийг дэглэхээр ажиллаж байна" гэж ярилаа.

Түүхийн үзүүлэгийг бүтээхэд өөрийн ур ухааныг зориулсан 1977 оны төгсөгч Ч.Цэен-Ойдов "Улс төрийн байгууллагын түүхийг хойч үедээ таниулан сурталчлах үйлсэд хувь нэмрээ оруулсандаа баяртай байна", бэлтгэл дэд хурандаа Я.Одсүрэн "Энэхүү үзүүлэгт өөрийн барьж байсан гармон хөгжмийг тоглож үзүүлээд хандивласан. Одоо дүрс бичлэгийн камера гардуулья" гэж хэллээ.

Энэ үеэр Монгол цэргийн музейн захирал хурандаа Д.Ганзориг "Манай музей сан хөмрөгтөө өдгөө 9740 орчим эд өлгийн зүйлтэй. Та бүхний бие сэтгэл шингэсэн зүйлс нь тус музей 10000 үзмэртэй болоход хувь нэмрээ оруулж байна" гэв.

Мөн Улс төрийн ангийн 1981 оны төгсөгч Д.Жамбалдорж "Түүхийн үзүүлэгийн цаашдын баяжилтад хувиасаа 300.000 төгрөг хандивлая" гээд Нэгдсэн эвлэлийн тэргүүн бэлтгэл хурандаа Б.Жуваад гардуулан өглөө.

Цэргийн улс төрийн ахмад ажилтан, Соёлын тэргүүний ажилтан, чөлөөнд байгаа хурандаа Г.Ганбатын "Цэргийн улс төрийн ажилтны яруу алдрын дуулал" найраглалыг ЗХЖШ-ын Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр уншиж сонсгов.

Уг танхимын шинэ үзүүлэгийн хэсгийн нээлтийг ЦДБЭЧ-ын уран бүтээлчид ая дуугаараа хөгжөөн баясгаж сэтгэлийн цэнгэл бэлэглэлээ.

"Зэвсэгт хүчний Соёл хүмүүжлийн ажилтны өдөр"-ийг угтсан дараагийн бодит ажил нь энэ сарын 20-ны өдөр Монгол цэргийн музейд зохиогдох 1983 оны төгсөгчдийн нэрэмжит Шатрын тэмцээнээр үргэлжлэх бол мөн сарын 26-ны өдөр Зэвсэгт хүчний 013 дугаар ангид Нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулахаар төлөвлөсөн ажээ.

**АХМАД ДАЙЧДЫН
"УЛААН ОДХОН" СОНИН**

ЦЭРЭГЖЛИЙН СПОРТЫН ШИЛДГҮҮДИЙГ ТОДРУУЛНА



Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах цэрэгжлийн буудлага, цэрэг-спорт цогцолборын зуны олон төрөлт, саадын зурвасын тэмцээнүүд зохион байгуулагдахад бэлэн боллоо.

Тэмцээнд Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлалууд, 30 гаруй нэгтгэл, ангийн 600 орчим тамирчин мэргэжлийн ур чадвар, цэц мэргэн, хурд хүчээ сорин

өрсөлдөхөөр бэлтгэлээ хангаж байгаа бөгөөд байлдагчаас хошууч генерал хүртэлх цолтнууд оролцохоор мэдүүлээ өгөөд байна.

Цэрэгжлийн спортоор хичээллэдэг алба хаагч бүрийн хүсэн хүлээдэг энэхүү тэмцээн 5 дугаар сарын 18-26-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Хужирбулан дахь Сургалтын төвд явагдана.

Тэмцээний техникийн зөвлөгөөн маргааш буюу 5 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдаж, 5 дугаар сарын 18-ны өдрөөс тамирчид гараанаас гарна.